

“Хот Девелопмент” ХК-ийн Хувьцаа Эзэмшигчдийн 2016.04.15-ны өдрийн

ээлжит хурлын тэмдэглэл

2016.04.15

Улаанбаатар хот

“Хот Девелопмент” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2016 оны 04 сарын 15-ны өдрийн 12 цаг 10 минутанд “Си Би Эм” ХХК-ийн хурлын өрөөнд эхлэв.

Хуралд: Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дарга, Гүйцэтгэх захирал Баярсайхан овогтой Пүрэвбаатар, хурал зохион байгуулах комиссын гишүүн Ж.Энхцэцэг, тооллогын комиссын дарга Б.Мянганбаяр, гишүүн Г.Бадамдорж нар оролцов.

Саналын хуудсаар Hot Holdings SARL, БиДиСек ХК хувьцаа эзэмшигчид оролцов.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дарга Б.Мянганбаяр хурлын ирцийг танилцуулав: “Хот Девелопмент” ХК-ийн 2016 оны 04 сарын 15-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын ирцийг та бүхэнд танилцуулья. Нийт 39,885 хувьцаанаас нийтдээ 82,02% буюу 32,713 ширхэг хувьцаа эзэмшиж буй 2 хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнтэйгээр хурлын ирц бүрдэж байгааг мэдэгдье.

Хурлын дарга Б.Пүрэвбаатар хувьцаа эзэмшигчдийн хурлын ээлжит хурлын дэгийг танилцуулав.

- ✓ Хурлын ирцийг бүртгэх
- ✓ Хурлын ирцийг мэдээлэх
- ✓ Хурлын дарга хурлыг нээх, хурлаар хэлэлцэх асуудлууд болон хурлын дэгийг танилцуулах
- ✓ Хурлаар хэлэлцэх асуудлуудыг дарааллын дагуу танилцуулах, санал авах
- ✓ Хурлын завсарлага
- ✓ Тооллогын комиссын тогтоолыг танилцуулах
- ✓ Хурлаас гарах шийдвэр, тогтоолыг танилцуулах
- ✓ Хурлыг хаах

Хурлаар хэлэлцэх асуудлууд:

1. Компанийн 2015 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах
2. Компанийн аудитын хорооны тайланг хэлэлцэн батлах
3. 2016 оны ажлын төлөвлөгөөг хэлэлцэн батлах
4. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
5. ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагын 2016 оны зардлын төсвийг батлах
6. Компанийн ногдол ашгийн талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг хэлэлцэн батлах

Тооллогын комиссын дарга Б. Мянганбаяр санал хураалтын дүнг танилцуулав:

1. Компанийн 2015 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай хувьцаа эзэмшигчид 100 % нь зөвшөөрсөн, 0 % нь татгалзсан, 0 % нь түдгэлзсэн байна.
2. Компанийн аудитын хорооны тайланг хэлэлцэн батлах тухай хувьцаа эзэмшигчид 100 % нь зөвшөөрсөн, 0 % нь татгалзсан, 0 % нь түдгэлзсэн байна.
3. 2016 оны ажлын төлөвлөгөөг хэлэлцэн батлах тухай хувьцаа 100 % нь зөвшөөрсөн, 0 % нь татгалзсан, 0 % нь түдгэлзсэн байна.
4. Компанийн шинэ ТУЗ-ийн гишүүдэд нэр дэвшигчдээс Жэймс Пассин 11,11%, Б.Батбаатар 11,11%, Б.Пүрэвбаатар 11,11%, Б.Лхагвадорж 11,11%, Д.Даянбилгүүн 11,11%, Жэймс Флорес 11,11% -ийн санал авч хараат гишүүдэд сонгогдлоо. Хараат бус гишүүдэд Б.Батхуяг 11,11%, Д.Нарангоо 11,11%, Т.Тамир 11,11%-ийн саналтайгаар сонгогдлоо.
5. ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагын 2016 оны зардлын төлөвлөгөө батлах тухай хувьцаа эзэмшигчид 100 % нь зөвшөөрсөн, 0 % нь татгалзсан, 0 % нь түдгэлзсэн байна.
6. Компанийн ногдол ашгийн талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг хэлэлцэн батлах тухай хувьцаа эзэмшигчид 100 % нь зөвшөөрсөн, 0 % нь татгалзсан, 0 % нь түдгэлзсэн байна.

Хурал 12:30 өндөрлөв.

Хурлын протокол хянасан
хурлын дарга:



/Б.ПҮРЭВБААТАР/

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:

/Ж.ЭНХЦЭЦЭГ/